

## **ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хоршооны тухай хуулийн 8.4-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-ноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд дагаж мөрдөх санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг тодорхойлох болон бусад хэм хэмжээг тогтоох түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо (цаашид Хоршоо гэх) нь өөрийн үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлийг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллана. Үүнд:

- 1.2.1 Актив хөрөнгийн хамгаалалтын үзүүлэлт;
- 1.2.2 Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;
- 1.2.3 Актив хөрөнгийн чанарын үзүүлэлт;
- 1.2.4 Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт;
- 1.2.5 Төлбөрийн чадварын үзүүлэлт;

1.3 Хоршоо нь энэ журмын 1.2-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тогтоон үнэлэлт, дүгнэлт өгөх замаар хоршооны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүнээс сэргийлэх арга хэмжээг авна.

1.4 Хоршоо нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавьж, удирдах зорилгоор нэмэлт дүрэм, журмыг дотооддоо боловсруулан мөрдүүлж болно. Тэдгээр нь Хоршооны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.5 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.5.1 *Актив хөрөнгө* гэдэг нь хоршооны үйл ажиллагааны үр дүнд үүсч бий болсон, түүний мэдэлд байгаа, ирээдүйд эдийн засгийн үр ашиг өгөх санхүүгийн нөөц болон чадавхийг хэлнэ.

1.5.2 *Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө* (цаашид ӨБҮХХ гэх) гэдэг нь зөвхөн зээл төлөлтийн тооцоогоор (зээлдэгчээс зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор хураан авсан хөрөнгө) бусдаас

өмчлөн авахад хүрсэн, хоршооны үйл ажиллагаанд хамааралгүй үл хөдлөх хөрөнгийг хэлнэ.

1.5.3 *Үндсэн хөрөнгө* гэдэг нь нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал, худалдах зориулалтгүй, хоршооны хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн, элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд анхны үнээ аажмаар шингээж байдаг биет хөрөнгийг хэлнэ.

1.5.4 *Хүүгийн орлого авчирдаг актив* гэдэг нь хүүгийн орлого олох зорилгоор байршуулагдсан активын үлдэгдлийн нийлбэр дүнг хэлнэ. (тухайлбал; зээл, Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, банкин дахь харилцах, хадгаламж гэх мэт)

1.5.5 *Зээл* гэдэг нь хоршооны гишүүнд тодорхой зориулалт, хугацаа, эргэж төлөгдөх нөхцөл, хүү, барьцаа, баталгаа эсвэл батлан даалттайгаар хоршооноос өөрийн гишүүнд мөнгөн хөрөнгө зээлдүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

1.5.6 *Зээлийн эрсдэлийн сан* гэдэг нь ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор урьдчилан тооцож хоршооны зардлаар байгуулсан санг хэлнэ.

1.5.7 *Зээлийн төвлөрөл* гэдэг нь хоршоо өөрийн хөрөнгийн 30-аас дээш хувийг нэг зээлдэгч буюу түүнд холбогдох этгээдэд шууд болон шууд бусаар олгосон байхыг хэлнэ.

1.5.8 *Санхүүгийн үр өгөөж* гэдэг нь хоршооны үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж активын дийлэнх хувийг хүү авчирдаг активт байршуулснаар хүү, шимтгэл болон үнийн зөрүү зэргээс хоршоологчдын орлогыг нэмэгдүүлэх хүчин зүйлийг хэлнэ.

1.5.9 *Хувь нийлүүлсэн хөрөнгө* гэдэг нь гишүүд эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн нийлбэр дүнг хэлнэ.

1.5.10 *Хоршоологчдын өмч* гэдэг нь хоршооны өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хассаны дараах өөрийн хөрөнгийг хэлнэ.

1.5.11 *Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар* гэдэг нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад төлбөрийн нэхэмжлэлийг анхны шаардлагаар гүйцэтгэж чадах чадамжийг хэлнэ.

1.5.12 *Төлбөрийн чавдар* гэдэг нь гишүүдээс хоршоонд нийлүүлсэн хөрөнгө болон гишүүдээс хадгалуулсан мөнгөн хөрөнгө, бусдад төлөх төлбөрийг бүрэн гүйцэтгэх чадамжийг хэлнэ.

1.5.13 *Богино хугацаа* гэдэг нь нэг жилээс бага хугацаагаар хадгалуулсан мөнгөн хөрөнгө, авсан зээл, олгосон зээл, худалдан авсан үнэт цаасны хугацааг ойлгоно.

## **ХОЁР. АКТИВ ХӨРӨНГИЙН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ**

2.1 Актив хөрөнгө нь бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах, хадгаламж, Засгийн газрын болон Төв банкны үнэт цаас, гишүүдэд олгосон зээл, санхүүгийн түрээсийн авлага, картын зээл, үндсэн хөрөнгө, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө, авлага болон бусад активаас бүрдэнэ.

2.2 Хоршооноос гишүүдэд олгосон зээлийн багцад Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2004 оны хамтарсан 207/459 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам” болон уг журамд 2006 онд оруулсан өөрчлөлт (хамтарсан 147/94 тоот тушаал)-ийн дагуу ангилал хийж, зээлийн эрсдэлийн санг байгуулна.

2.3 Зээл, Засгийн газар, Төв банкны үнэт цаас, бусад активтай холбоотой гэрээ, хэлцлийн дагуу үүрэг хүлээсэн этгээд нь үндсэн өр, түүний хүүгийн төлбөрийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан төлөх чадваргүй болж болзошгүй нь үндэслэл бүхий баримт (зээлийн гэрээний хугацаа дууссан, барьцаа хөрөнгийн чанар муудсан, зах зээлийн үнэ буурсан, байгалийн болон гэнэтийн эрсдэл учирсан гэх мэт)-аар тогтоогдвол хоршоо нь эрсдэлийн санг зардлаар байгуулна.

2.4 Хэвийн ангилалд байгаа зээл болон түүнтэй адилтгах активыг санхүүгийн тайлан тэнцэлд анх тусгах үед эрсдэлийн санг байгуулахгүй.

2.5 Зээл, Засгийн газар, Төв банкны үнэт цаас, ӨБҮХХ болон бусад активыг ангилахад хугацааны үзүүлэлт нь үндсэн хүчин зүйл, чанарын үзүүлэлт нь харгалзах хүчин зүйл байх болно. Хугацааны ба чанарын үзүүлэлтийг энэ бүлгийн 2.2-д заасан журмын хавсралтад заасан хүчин зүйлсээр тооцон ангилна.

2.6 Хоршооны цэвэр актив хөрөнгийн дүнг тооцохдоо тэнцлийн актив утгатай дансны үлдэгдлийн нийлбэр дүнгээс актив тус бүрт байгуулсан болзошгүй эрсдэлээс хамгаалах сангууд болон үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг хасч тооцно.

2.7 Нийт орлого авчирдаг актив хөрөнгийн дүн нь нийт активын 80-аас дээш хувийг эзэлж байвал зохино.

2.8 Зээл, Засгийн газар, Төв банкны үнэт цаас, ӨБҮХХ болон бусад активын эрсдэлийн санг хугацааны болон чанарын үзүүлэлт өөрчлөгдөх тухай бүр дараах ангиллалаар ангилах бөгөөд актив хөрөнгийн хамгаалалтыг доорх хувь хэмжээгээр байгуулна. Үүнд:

2.8.1 Хугацаа хэтэрсэн	5 хувь
2.8.2 Чанаргүй, үүнээс:	
a/ хэвийн бус	40 хувь
б/ эргэлзээтэй	75 хувь
в/ муу	100 хувь

2.9 Зээл, Засгийн газар, Төв банкны үнэт цаас, ӨБҮХХ болон бусад активын эрсдэлийн санг энэ бүлгийн 2.2-д заасан журамд зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

2.10 Төлбөрийн чадварыг тооцохдоо нийт активыг нийт өр төлбөрт харьцуулах замаар тооцно. Энэ харьцаа нь 110 хувиас дээш байх байвал зохино.

## **ГУРАВ. ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

### **3.1 АКТИВ**

3.1.1 Бэлэн мөнгөний дансан дахь үлдэгдэл нь орлого авчирдаггүй актив бөгөөд хоршоо нь эрсдэлийг багасгах, төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх зорилгоор тодорхой хэмжээний бэлэн мөнгийг касс байлгана. Касс дахь бэлэн мөнгө нь нийт активын 2 хувиас ихгүй байвал зохино.

3.1.2 Нийт зээлийн өрийн үлдэгдэл нь нийт актив хөрөнгийн 70-80 хүртэлх хувь байвал зохино.

3.1.3 Худалдан авсан Засгийн газар болон Төв банкны үнэт цаасны нийт хэмжээ нь нийт активын 10 хувиас хэтрэхгүй байвал зохино.

3.1.4 ӨБҮХХ нь нийт актив хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байвал зохино. (ӨБҮХХ-ийн нийт активд эзлэх хувийн жин нь нэмэгдэж байгаа нь хоршооны зээлийн эргэн төлөлт муу байгааг харуулж, түргэн борлогдох актив хөрөнгийн хомсдолыг бий болгодог)

3.1.5 Хоршооны үндсэн хөрөнгө нь нийт активын 5 хувиас хэтрэхгүй байвал зохино.

### **3.2 ПАССИВ**

3.2.1 Гишүүдээс хоршоонд хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт өр төлбөрийн 90-ээс дээш хувь, нийт активын 70 хүртэлх хувь байвал зохино.

3.2.2 Хоршооны бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл нь нийт активын 5 хувиас хэтрэхгүй байвал зохино.

3.2.3 Хоршооны хоршоологчдын өмч нь нөөцийн сан, дахин үнэлгээний сан, нийгмийн хөгжлийн сан, хандив, тусламж, бусад сангууд болон тухайн үеийн ашиг/алдагдал, хуримтлагдсан ашиг/алдагдал, бусад өмчөөс бүрдэнэ. Хоршооны хоршоологчдын өмч нь нийт активын 5 хувиас дээш байвал зохино.

3.2.4 Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт активын 2 хувиас дээш, өөрийн хөрөнгийн 30 хувиас доош байвал зохино.

3.2.5 Хоршооны нөөцийн сангийн хэмжээ нь хоршоологчдын өмчийн 40 хувиас дээш байвал зохино.

## **ДӨРӨВ. АКТИВ ХӨРӨНГИЙН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ**

### 4.1 Зээлийн төвлөрөл:

4.1.1 Хоршооны нэг гишүүнд олгох зээлийн дүн нь нийт зээлийн багцын 10 хувиас хэтрэхгүй, нэг гишүүнд болон түүнд холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн дүн нь өөрийн хөрөнгийн 30 хувиас ихгүй байвал зохино.

4.1.2 Хоршооны хувь нийлүүлэгчид, Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл, ажиллагсад олгох зээл нь зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл нь өөрийн хөрөнгийн 6 хувиас хэтрэхгүй байвал зохино.

4.1.3 Энэ журмын 4.1.1, 4.1.2-д зааснаас бусад төвлөрлийн эрсдэлийг зохих түвшинд нь барьж байх хязгаарлалтыг хоршоо өөрөө тогтоож, дүрэмд тусган, дотооддоо мөрдүүлнэ.

### 4.2 Зээлийн чанар:

Зээлийн багцын чанарыг тооцож гаргахдаа зээлийн ангилал (хэвийн зээл, хугацаа хэтэрсэн зээл, хэвийн бус зээл, эргэлзээтэй зээл, муу зээл) тус бүрийг нийт зээлийн өрийн үлдэгдлийн дүнд харьцуулна. Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нь нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй байвал зохино.

## **ТАВ. ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

5.1 Зээлийн багцын өгөөжийг тооцохдоо зээлийн үйл ажиллагаанаас олсон орлогыг зээлийн багцын дунджид харьцуулах замаар тооцох ба энэхүү харьцаа нь зах зээлийн дунджаас бага байвал зохино.

5.2 Хоршоо нөөцийн сангаа жил бүрийн ашгаас 10 хувиас багагүй хэмжээгээр тооцож байгуулах бөгөөд нөөцийн сангийн зарцуулалтыг хоршооны бүх гишүүдийн хурлаас баталсан журмын дагуу зарцуулна.

5.3 Хоршооны үйл ажиллагааны зардал нь хөрөнгийн удирдлагатай холбоотой бөгөөд нийт активын 5 хувиас бага байвал зохино.

5.4 Нэг төгрөгийн актив хөрөнгөөс ямар хэмжээний орлого олж байгааг тооцохдоо татварын өмнөх цэвэр ашгийг нийт активын дундажтай харьцуулах бөгөөд энэхүү харьцаа нь зах зээлийн хүүгийн түвшингөөс өндөр байвал зохино.

5.5 Хоршооны орлого, зарлагын тайлангаар үйл ажиллагааны үр дүн, ашиг алдагдал, зардлыг хэрхэн удирдаж, хэмнэлт гаргах, санхүүгийн тогтвортой байдал, бодит өсөлтийг хэрхэн удирдахыг тооцоолно. Тухайлбал;

5.5.1 *Хүүгийн орлого, нийт дундаж активын харьцаа:* Бүх төрлийн хүүгийн орлогыг нийт активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.2 *Хүүгийн зардал, нийт дундаж активын харьцаа:* Бүх төрлийн хүүний зардлыг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.3 *Хүүгийн цэвэр орлого, нийт дундаж активын харьцаа:* Хүүгийн орлогоос хүүгийн зардлыг хассан дүнг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.4 *Хүүгийн бус орлого, нийт дундаж активын харьцаа:* Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, бусад төрлийн орлогуудын нийлбэр дүнг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.5 *Хүүгийн бус зардал, нийт дундаж активын харьцаа:* Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн зардал, боловсон хүчний холбогдолтой зардал, болзошгүй эрсдэлийн зардлаас бусад төрлийн зардлуудын нийлбэр дүнг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.6 *Үйл ажиллагааны цэвэр орлого, нийт дундаж активын харьцаа:* Хүүгийн цэвэр орлого, хүүгийн бус орлогын нийлбэр дүнгээс хүүгийн бус зардлыг хассан дүнг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.7 *Болзошгүй эрсдэлийн зардал, нийт дундаж активын харьцаа:* Бүх төрлийн болзошгүй эрсдэлийн зардлуудын нийт дүнг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.8 *Татварын өмнөх орлого, нийт дундаж активын харьцаа:* Үйл ажиллагааны цэвэр орлогоос болзошгүй эрсдэлийн зардлуудыг хассан дүнг активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.9 *Хүүгийн орлого, хүүгийн орлого оруулдаг нийт дундаж активын харьцаа:* Бүх төрлийн хүүний орлогыг хүүгийн орлого оруулдаг нийт активын дундаж үлдэгдэлд харьцуулна.

5.5.10 *Зээлийн сан, нийт зээлийн өрийн үлдэгдлийн харьцаа:* Зээлийн санг нийт зээлийн өрийн үлдэгдэлд харьцуулан дүгнэлт хийх гэх мэт.

## **ЗУРГАА. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ**

6.1 Энэхүү харьцаа (бэлэн мөнгө болон богино хугацаанд бэлэн мөнгөнд хөрвүүлж болох хөрөнгө) нь багассан болон огцом буурсан нөхцөлд гишүүдийн хадгалуулсан хадгаламжийн мөнгийг тавьж олгоход эрсдэл үүснэ.

6.2 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн түвшинг тооцохдоо түргэн борлогдох активыг нийт гишүүдээс татсан хадгаламж, бусдаас авсан богино хугацаатай зээлийн эх үүсвэрийн нийлбэрт харьцуулах замаар тооцно. Энэ харьцаа нь 15 хувиас дээш байвал зохино.

## **ДОЛОО. БУСАД**

7.1 Энэхүү журамд заагдсан зохистой харьцааг байнга ханган ажиллаж байгаа эсэхэд хоршооны бүх гишүүдийн хурал, Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл,

Эрсдэлийн хороо болон хоршооны дарга нь хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд хяналт тавина.

7.2 Хоршоо дор дурдсан тайланг улирал бүрээр гарган, дараа сарын 10-ны өдрийн дотор Хорооны Мониторинг, судалгааны газарт бичгээр болон файлаар ирүүлнэ. Үүнд:

- 7.2.1 Зохистой харьцааны үзүүлэлтүүдийн хураангуй /Хавсралт 1/
- 7.2.2 Актив хөрөнгийн хамгаалалтын тайлан /Хавсралт 2/,
- 7.2.3 Үр ашигтай санхүүгийн бүтцийн тайлан /Хавсралт 3/
- 7.2.4 Активын чанарын үзүүлэлтийн тайлан / Хавсралт 4/
- 7.2.5 Өгөөж, зардлын хувь хэмжээний тайлан /Хавсралт 5/
- 7.2.6 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн тайлан /Хавсралт 6/
- 7.2.7 Хоршооны хураангуй тайлан тэнцэл /Хавсралт 7/
- 7.2.8 Орлого, зарлагын тайлан /Хавсралт 8/
- 7.2.9 Хоршооны хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл болон бусад актив хөрөнгийн тайлан /Хавсралт 9/
- 7.2.10 Хоршооны 20 том зээлдэгчид олгосон зээл болон бусад актив хөрөнгийн тайлан /Хавсралт 10/,
- 7.2.11 Их хэмжээний хувь нийлүүлсэн гишүүдийн тайлан /Хавсралт 11/
- 7.2.12 Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны тайлан /Хавсралт 12/

7.3 Хадгаламж зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд Хороо хяналт тавьж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг авна.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

**2007 оны 02 сарын 02 өдөр**

**Дугаар 17**

**Улаанбаатар хот**

**Журам батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хоршооны тухай хуулийн 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталж, 2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, нийтэд сурталчлан ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН